



ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Эрдэм шинжилгээний бүтээл” (Bulletin of Institute of Chemistry and Chemical Technology, BICCT) сэтгүүлийн Дугаар 11 буюу 2023 оны шинэхэн дугаарыг эрхэм та бүхэнд хүргэж байна. Манай сэтгүүлд сүүлийн үеийн судалгааны ажлын шинэ үр дүн, шинэлэг санаагаа нэгтгэн өгүүллээ ирүүлсэн эрдэмтэн судлаачид та бүхэндээ талархал илэрхийлье. Тус сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлүүд нь DOI дугаартай гардаг бөгөөд бид хайлтын системийн бүртгэлийг өргөжүүлэхэд ихэд анхаарч ажиллаж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт эрдэс боловсруулалт, нефтийн ба нүүрсний хими, биохимийн салбараас гадна математик-химийн салбар шинжлэх ухааныг холбосон туршилтын төлөвлөлт-оновчлолын загварчлал болон интеграл тэгшитгэлийн онолыг хийн холимог системд ашиглах чиглэлээр бичигдсэн нийт 7 өгүүлэл сэтгүүлийн шаардлагыг ханган хэвлэгдэж байна. Хэвлэгдсэн бүтээлүүдээс онцолбол:

Ш.Нямдэлгэр нарын судлаачид “Усан уусмал дахь зэс (II)-ийн LIX984N хандлагчаар хандлагдах нөхцөлийг оновчлох загварчлал”-аар зэсийн сульфидын баяжмалыг исэлдүүлэн шатаасны дараа усанд уусган, уг уусмал дахь зэсийг органик хандлагчаар хандлах хандлалтын оновчтой горимыг математик төлөвлөлтийн аргаар тогтоожээ. Түүнчлэн судлаач Д.Сарангэрэл нар газрын ховор элемент агуулсан синхизитийн хүдрийг биологийн аргаар уусган баяжуулж, металл авалтыг дээшлүүлэх боломжтой гэж үзэв.

Органик химичид Тамсагбулаг, Цагаан-Элсний ордуудын нефть, тэдгээрийн атмосфер үлдэгдлийг дулааны крекинг процессоор шингэрүүлэх боломжтойг тогтоосон бол Ц.Ариунсайхан нарын судлаачид арьс ширний үйлдвэрийн уурагт хаягдлын шинж чанарын судалгааг явуулж, уурагт суурилсан бүтээгдэхүүний түүхий эд болгон ашиглахад хромыг зайлуулах шаардлагатайг санал болгожээ.

Физикчид метан, этаны холимог системд интеграл тэгшитгэлийн онолыг нэгдсэн атомт загвартай хослуулан системийн бүтцийг тодорхойлох радиал түгэлтийн функцийг дүрсэлж, дотоод энергийг тооцоолсон байна.

Манай сэтгүүлтэй нэгэн сэтгэлээр хамтран ажиллаж буй хөндлөнгийн шүүмжлэгч нартаа талархал илэрхийлэхийн сацуу эрхэм эрдэмтэн судлаач та бүхнийг эрдэм шинжилгээний шинэхэн өгүүлүүдээ ирүүлэхийг урьж байна.

Улс орны хөгжлийн түлхүүр болсон Монгол улсын шинжлэх ухаан хөгжин цэцэглэх болтугай.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР ЛХАСҮРЭНГИЙН ЖАРГАЛСАЙХАН